

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

**ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

№	Захирамжийн огноо	Захирамжийн дугаар	Захирамжийн утга	Нийт дүн	Шилжүүлсэн байгууллага	Огноо
1	2018-03-22	а/96 /2016-2020 УАХЗ/	Орон нутгийн хэвэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах тухай	14,400,000₮	Таны сэлэнгэ, Миний монгол, Шинэ гэгээ, Монцамэ, МУОНРТ, Нутаг 21, ТВ9, Молор	2018-10-18
2	2018-10-01	A/364	Хөрөнгө гаргах тухай	1,980,000₮	СХЗГ	2018-10-09
3	2018-08-24	A/327	Буцалтгүй тусламж үзүүлэх тухай	1,000,000₮	Я.Мөнхсайхан	2018-10-09
4	2018-09-17	A/346	Буцалтгүй тусламж үзүүлэх тухай	1,000,000₮	Ш Онон	2018-10-09

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллээ байршуулаагүй байна.

**Сүхбаатар сум 2018 он**

## Агуулга

**Тайланг****бэлтгэсэн:**

Сэлэнгэ аймаг  
дахь Төрийн  
Аудитын газар

Дарга, тэргүүлэх  
аудитор  
Ч.Энхтуяа

Аудитын менежер  
Б.Батмөнх

Ахлах аудитор  
Ц.Отгонбаяр  
С.Бат-Эрдэнэ

Аудитор  
З.Золбоо

**2018 оны 10-11  
сар**

Аудитын тайлан,  
дүгнэлттэй  
холбоотой  
асуудлаар нэмж  
тодруулах, асууж  
лавлах зүйл  
байвал 70362442,  
70363036  
дугаарын утас,  
70363040  
дугаарын факсаар  
харилцана уу.

**ХАЯГ:**

Сэлэнгэ аймгийн  
Сүхбаатар сум  
аймгийн ЗДТГ-ын  
байрны өргөтгөлд

Товчилсон үгийн жагсаалт.....  
Аудит хийх үндэслэл.....  
Аудитын зорилт.....  
Аудитын хамрах хүрээ.....  
Арга зүй.....  
Шалгуур үзүүлэлт, хугацаа.....  
Ерөнхий мэдээлэл.....  
Аудитын дүн:.....

**БҮЛЭГ.I Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12091 удаагийн мэдээллээс 11260 буюу 92.8 хувийг мэдээлсэн байна.**

*1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12091 удаагийн мэдээллээс 11260 удаагийн буюу 92.8 хувийг мэдээлсэн байна.*

*1.2. Аймгийн ЗДТГ, ИТХ нь төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбаргүй байна.*

**БҮЛЭГ.II Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллээ байршуулаагүй байна.**

*2.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.*

*2.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллээ байршуулаагүй байна.*

*2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 177 удаагийн мэдээллээс 27 удаагийн мэдээллийг хугацаанд нь, 38 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн буюу 36.7 хувийг мэдээлсэн байна.*

**БҮЛЭГ.III Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулаагүй байгаа тул ТЕЗ-ийн зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.**

3.1 ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан боловч багийн иргэдийн Нийтийн Хурлын зүгээс хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

3.2 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулаагүй байгаа тул ТЕЗ-ийн зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.3 Тухайн нэгж байгууллагын Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хандсан хэрэглэгчийн тоог хянах бололцоогүй, мөн иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан ач холбогдолтой мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд шуурхай өгч байгаа эсэхэд дүгнэлт өгөх бололцоогүй байна.

3.4 Өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн бол зөвлөмжийн биелэлт 75 хувьтай байна.

**Илрүүлсэн зөрчил.....**

**Дүгнэлт.....**

**Зөвлөмж.....**

**Холбогдох байгууллагын санал.....**

**Хавсралтууд.....**

## Товчилсон үгийн тайлбар

<b>ААН</b>	Аж ахуй нэгж
<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
<b>АЗЗА</b>	Авто зам, засвар арчлалт
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЗАА</b>	Захирагчийн ажлын алба
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ИНХ</b>	иргэдийн Нийтийн Хурал
<b>ИТХ</b>	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>МСҮТ</b>	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
<b>МЭҮН</b>	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
<b>ОНЕД</b>	Орон нутгийн ерөнхий данс
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ОНӨҮГ</b>	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ӨЭМТ</b>	Өрхийн эрүүл мэндийн төв
<b>СТСХ</b>	Санхүү төрийн сангийн хэлтэс
<b>ТАХ</b>	Төсөл арга хэмжээний тоо
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ТБОНӨХБАУХА</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТЗШ</b>	Тусгай зориулалтын шилжүүлэг
<b>ТӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани
<b>ТҮГ</b>	Тохижилт үйлчилгээний газар
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ШШГЕГ</b>	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

### **1. Аудит хийсэн үндэслэл**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж гүйцэтгэв.

### **2. Аудитын зорилт, хамарсан хүрээ**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалган дүгнэлт, зөвлөмж өгч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд нийцлийн аудитын зорилт оршив. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх,
2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх,
3. Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

Аудитад 2017 оны 4-р улирал, 2018 оны 3-р улирлын байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах улсын төсвийн 44, орон нутгийн төсвийн 174, аймаг, сумдын ТЭЗ 18, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 14, төрийн өмчит компани 1, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгж 97, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээ үзүүлж буй байгууллага 55 зэрэг нийт 403 хуулийн этгээдийг хамруулав.

### **3. Аудитын арга зүй:**

Аудитаар АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудын мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Санхүүгийн хяналт, аудитын албаны ажилтнууд, төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогчид болон холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судлах, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, лавлагаа тайлбар авах, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, давтан тооцоолол хийх, иргэдээс санал асуулга авч дүнг нэгтгэн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

#### 4. Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

“Төсвийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “ТБОНӨХБАҮХА тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 01-р сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” болон бусад холбогдох хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, С.Бат-Эрдэнэ, аудитор З.Золбоо нар 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

#### 5. Ерөнхий мэдээлэл

Сэлэнгэ аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах төрийн болон орон нутгийн өмчит байгууллага 218, ОНӨААТҮГ болон ОНӨҮГ 14, аймаг, сумдын ТЕЗ 18, ТӨХК 1, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 97 аж ахуйн нэгж, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг үзүүлдэг 55 байгууллага зэрэг нийт 403 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх хуулийн этгээдүүдийн шилэн дансны цахим санд өөрийн нэрээр цэс үүсгэсэн болон мэдээлэл байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Хууль, журмын заалт	Байгууллагын төрөл	2017 оны 3-р улирал		2018 оны 3-р улирал	
		Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын тоо	Мэдээлэл байршуулсан байгууллагын тоо	Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын тоо	Цэс үүсгэсэн болон мэдээлэл байршуулсан байгууллагын тоо
3.1.1 дэх заалт	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	232	229	218	218
3.1.1 дэх заалт	ОНӨААТҮГ болон ОНӨҮГ			14	12

3.1.2 дахь заалт	Төрийн өмчит үйлдвэрийн газар	-	-	-	-
3.1.3 дахь заалт	Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани	1	1	1	1
ЗГ-ын 29-р тогтоолоор батлагдсан журмын дагуу	Төсвийн ерөнхийлөн захирагч	18	18	18	18
3.1.4 дэх заалт	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага	113	113	97	0
3.1.5 дахь заалт	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч	22	12	55	33
<b>Нийт дүн</b>		<b>386</b>	<b>373</b>	<b>403</b>	<b>282</b>

Дээрх хүснэгтээс харахад хуулийн 3.1.1, 3.1.3-д заасан 231 байгууллага мэдээллээ байршуулсан бол Хүдэр тохижилт, Сэлэнгэ баялаг ирээдүй ОНӨААТҮГ-ууд нь цэс үүсгэж, мэдээлэл байршуулаагүй байна.

Тайлант хугацаанд 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлсэн хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан нийт 152 хуулийн этгээд байгаагаас шилэн дансны цахим хуудсанд 3.1.5-д заасан 33 ААН, байгууллага мэдээллээ байршуулсан бол 119 хуулийн этгээд мэдээлэл байршуулаагүй байна.

## АУДИТЫН ДҮН

### Бүлэг I

*Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх*

*Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12091 удаагийн мэдээллээс 11260 буюу 92.8 хувийг мэдээлсэн байна.*

**1.1Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх?**

*Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12091 удаагийн мэдээллээс 11260 удаагийн буюу 92.8 хувийг мэдээлсэн байна.*

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2018 оны 3 дугаар улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээний 3.1.1-д хамаарах улсын төсөвт 44, орон нутгийн төсөвт 174, аймаг, сумдын ТЕЗ 18, ОНӨААТҮГ болон ОНӨҮГ 14 зэрэг нийт 250 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх 250 хуулийн этгээд шилэн дансны цахим санд өөрийн нэрээр цэс үүсгэх ёстой боловч 2017 оны 11-р сард шинээр байгуулагдсан “Сэлэнгэ баялаг ирээдүй”, “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ-ууд нь цэс үүсгээгүй байна.

Тайлант оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит 250 хуулийн этгээд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12091 удаагийн мэдээллээс 11260 удаагийн буюу 92.8 хувийг мэдээлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Мэдээлбэл зохих	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорч мэдээлсэн	Нийт мэдээлсэн дүн	Мэдээлсэн дүн хувиар
Улсын төсөвт	44	3693	3525	74	3599	97.5%
Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага	192	7067	5999	471	6470	91.6%
ОНӨААТҮГ	14	1331	1085	106	1191	89.5%
<b>Дүн</b>	<b>250</b>	<b>12091</b>	<b>10609</b>	<b>651</b>	<b>11260</b>	<b>92.8%</b>

Дээрх судалгаанаас үзэхэд мэдээлбэл зохих мэдээлийг улсын төсвийн 44 хуулийн этгээд 97.5 хувийг, орон нутгийн төсвийн 192 хуулийн этгээд 91.6 хувийг, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд 89.5 хувийг тус тус мэдээлсэн байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах 403 хуулийн этгээд нь нийт 12091 удаагийн 111,154.2 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим санд мэдээлэхээс 11260 удаагийн 108,597.7 сая төгрөгийн мэдээллийг байршуулсан нь мэдээлбэл зохих мэдээллийн тооны хувьд 92,8 хувийн, мөнгөн дүнгийн хувьд 97 хувийн хэрэгжилттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

Байгууллагын төрөл	Мэдээллийн тоо			Мөнгөн дүн /сая төгрөгөөр/		
	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хувь	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хувь
Улсын төсөвт	3693	3599	97,5 %	69,333.1	68,499.4	99%
Аймгийн ТЕЗ-ийн харьяа	7067	6470	91,6 %	26,905.9	25,508.6	95%



байгууллага						
ОНӨААТҮГ	1331	1191	89,5 %	14,915.2	14,589.7	98%
<b>ДҮН</b>	<b>12091</b>	<b>11260</b>	<b>92,8 %</b>	<b>111,154.2</b>	<b>108,597.7</b>	<b>97%</b>

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-т заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хуулийн 6.1-6.3-т заасан 17-21 төрлийн мэдээллийг **ТОГТМОЛ ХУГАЦААНД** нийтэд ил тод мэдээлэхээр хуульчлагдсан байна.

Тайлант оны 3-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд улсын төсвийн 44 , орон нутгийн төсвийн 174 байгууллага, ТЭЗ- 18, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 14 зэрэг нийт 250 хуулийн этгээд давхардсан тоогоор 5518 удаагийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхээс 5070 удаагийн буюу 91.9 хувийн мэдээллийг мэдээлсэн байна.

Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

Хуулийн заалт	Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд тогтмол хугацаанд мэдээлэл байршуулсан байдал	Мэдээлбэл зохих мэдээллийн тоо					Үүнээс цахимаар болон самбараар мэдээлсэн тоо								
							Хугацаандаа мэдээлсэн					Хугацаа хоцроож мэдээлсэн	Мэдээлсэн нийт дүн	Мэдээлсэн хувь	
		Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЭЗ /ОНЕД/	ОНӨА АТҮГ	Дүн	Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЭЗ /ОНЕД/	ОНӨА АТҮГ	Дүн	Дүн			
	Байгууллагын тоо	44	174	18	14	250	44	174	18	14	250	250			
	<b>Нийт мэдээлэх тоо</b>	<b>968</b>	<b>3828</b>	<b>414</b>	<b>308</b>	<b>5518</b>	<b>850</b>	<b>3148</b>	<b>331</b>	<b>114</b>	<b>4443</b>	<b>627</b>	<b>5070</b>	<b>91.9%</b>	
6.1.1.	Тухайн жилийн төсөв	44	174	18	14	250	34	123	16	8	181	49	230	92.0%	
	ОНХС-ийн төлөвлөгөө	0	0	18	0	18	0	0	14	0	14	4	18	100.0%	
	ХАА-ны төлөвлөгөө	44	174	18	14	250	19	88	16	4	127	29	156	62.4%	
6.1.2.	Сар улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор	528	2088	216	168	3000	492	1809	172	54	2527	396	2923	97.4%	
	Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор	44	174	18	14	250	41	154	16	9	220	17	237	94.8%	
	Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор	44	174	18	14	250	42	161	17	9	229	8	237	94.8%	
6.1.3.	Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор	44	174	18	14	250	33	126	13	1	173	35	208	83.2%	
6.1.4.	Санхүүгийн тайлан /хагас жил/	44	174	18	14	250	37	150	17	7	211	17	228	91.2%	
	Санхүүгийн тайлан /жилийн эцсийн/	44	174	18	14	250	39	146	12	8	205	14	219	87.6%	
6.1.5.	ТЭЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	44	174	18	14	250	36	136	12	6	190	7	197	78.8%	
	Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	44	174	18	14	250	35	96	10	0	141	42	183	73.2%	
6.1.6.	Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	44	174	18	14	250	42	159	16	8	225	9	234	93.6%	

Дээрх судалгаанаас үзэхэд ОНХС-гийн төлөвлөгөөний мэдээллийг 100.0 хувь мэдээлсэн бол дараах 5 төрлийн мэдээллийг бага буюу 62.4-87.6 хувьтай мэдээлсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа №1-д харуулав./

Үүнд:

- Хуулийн 6.1.1-д заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс 127 нь хугацаандаа, 29 нь хугацаа хоцроож мэдээлж, 85 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.3-т заасны дагуу дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс 173 нь хугацаандаа, 35 нь хугацаа хоцроож мэдээлж, 40 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.4-т заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04-р сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс 205 нь хугацаандаа, 14 нь хугацаа хоцроож мэдээлж, 27 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.5-д заасны дагуу ТЕЗ-ийн төсвийн багацд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс 190 нь хугацаандаа, 7 нь хугацаа хоцроож мэдээлж, 53 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.5-д заасны дагуу аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор мэдээлэхээс 141 нь хугацаандаа, 42 нь хугацаа хоцроож мэдээлж, 66 нь мэдээлээгүй байна.

Харин дараах 6 төрлийн мэдээллийг 91.2-97.4 хувьтай мэдээлжээ. Үүнд:

- Хуулийн 6.1.1-д заасны дагуу тухайн жилийн төсвийг жил бүрийн 01-р сарын 10-ны дотор мэдээлэхээс 181 нь хугацаандаа, 49 нь хугацаа хоцроож мэдээлж, 20 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.2-т заасны дагуу сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор 3000 удаа мэдээлэхээс 2527 нь хугацаандаа, 396 нь хугацаа хоцроож мэдээлж, 73 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.2-т заасны дагуу хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор 220 нь хугацаандаа, 17 нь хугацаа хоцроож мэдээлж, 13 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.2-т заасны дагуу өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор 229 нь хугацаандаа, 8 нь хугацаа хоцроож мэдээлж, 9 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.4-т заасны дагуу хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор 211 нь хугацаандаа, 17 нь хугацаа хоцроож мэдээлж, 20 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.6-д заасны дагуу төсвийн хэтрэлт хэмнэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлэхээс 225 нь хугацаандаа, 9 нь хугацаа хоцроож мэдээлж, 16 нь мэдээлээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан 4-12 төрлийн мэдээллийг **7 хоногийн дотор** нийтэд ил тод мэдээлэхээр хуульчилсан байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 250 хуулийн этгээд нь 7 хоногийн дотор 4-

12 төрлийн 6388 удаагийн мэдээллийг нийтэд ил тод эдээлэхээс 6195 удаагийн буюу 97.0 хувийг цахим хуудсаар мэдээлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5

Хуулийн заалт	3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 3-р улирлын байдлаар 7 хоногийн дотор нийтэд ил тод болгох мэдээлэл	Мэдээлбэл зохих мэдээллийн тоо					Үүнээс цахимаар болон самбараар мэдээлсэн тоо							
							Хугацаандаа мэдээлсэн					Хугацаа хоцроож мэдээлсэн	Мэдээлсэн тоо	Мэдээлсэн хувь
		Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЕЗ /ОНЕД/	ОНӨА АТҮГ	Дүн	Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЕЗ /ОНЕД/	ОНӨА АТҮГ	Дүн	Дүн		
Байгууллагын тоо		44	174	18	14	250	44	174	18	14	250	250		
<b>Нийт мэдээлэх тоо</b>		<b>2714</b>	<b>2365</b>	<b>304</b>	<b>1005</b>	<b>6388</b>	<b>2672</b>	<b>2248</b>	<b>290</b>	<b>971</b>	<b>6181</b>	<b>14</b>	<b>6195</b>	<b>97.0%</b>
6.4.1.	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	44	174	18	14	250	44	169	18	9	240	5	245	98.0%
6.4.2.	Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хэлсний хэмжээнд орсон өөрчлөлт	35	40	18	12	105	35	40	18	8	101	2	103	98.1%
6.4.3.	Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	28	0	16	7	51	28	0	13	6	47	1	48	94.1%
6.4.4.	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	265	504	227	246	1242	242	467	219	239	1167	0	1167	94.0%
6.4.5.	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	850	579	0	305	1734	842	545	0	300	1687	0	1687	97.3%
	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	1259	66	0	312	1637	1250	66	0	311	1627	0	1627	99.4%
6.4.6.	Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн	44	174	18	14	250	42	159	15	9	225	4	229	91.6%
6.4.7.	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	41	174	0	14	229	41	173	0	10	224	2	226	98.7%
6.4.8.	Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	148	654	7	81	890	148	629	7	79	863	0	863	97.0%

Дээрх судалгаанаас үзэхэд 9 төрлийн мэдээллийг 91.6-99.4 хувьтай мэдээлсэн байна. Үүнд:

- Хуулийн 6.4.1-т заасны дагуу тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 240 нь хугацаандаа, 5 нь хугацаа хоцроож мэдээлж, Сэлэнгэ баялаг ирээдүй, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг, Хүдэр тохижилт зэрэг 3 ОНӨААТҮГ, Баянгол сумын ЭМТ, Хушаат сумын цэцэрлэг нийт 5 байгууллага мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.2-т заасны дагуу тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг 101 нь хугацаандаа, 2 нь хугацаа хоцроож мэдээлж, Хүдэр тохижилт, Хүдэр ойн анги 2 ОНӨААТҮГ нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.3-т заасны дагуу тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 47 нь хугацаандаа, 1 нь хугацаа хоцроож мэдээлж, Баруунбүрэн, Жавхлант, Шаамар сумын ТЕЗ нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.4-т заасны дагуу 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээлэл болох 566 удаагийн 9,082.1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлэхээс 521 удаагийн 8,260.4 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, ШШГЕГ-ын 433-р хаалттай хорих анги нь 16 удаагийн 500.0 сая төгрөгийн, Шаамар сумын МСҮТ нь 4 удаагийн 64.7 сая төгрөгийн, Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ нь 7 удаагийн 232.4 сая төгрөгийн зэрэг нийт 45 удаагийн 821.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.5-д заасны дагуу цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1734 удаагийн 34,236.7 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлэхээс 1687 удаагийн 33,604.0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, Орхонтуул сумын 1-р сургууль нь 9 удаагийн 115.4 сая төгрөгийн, 2-р сургууль нь 6 удаагийн 73,8 сая төгрөгийн, Хушаат сумын ЕБС нь 6 удаагийн 62.3 сая төгрөгийн, Мандал сумын 3-р сургууль нь 5 удаагийн 89.4 сая төгрөгийн, Шаамар сумын МСҮТ нь 5 удаагийн 50.9 сая төгрөгийн зэрэг нийт 47 удаагийн 632.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.5-д заасны дагуу цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1637 удаагийн 46,798.6 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг мэдээлэхээс 1627 удаагийн 46,686.4 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, ШШГЕГ-ын 433-р хаалттай хорих анги нь 9 удаагийн 70.8 сая төгрөгийн, Цант орхон ХХК нь 1 удаагийн 41.4 сая төгрөг буюу нийт 10 удаагийн 112.2 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.6-д заасны дагуу худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүнг 225 нь хугацаандаа, 4 нь хугацаа хоцроож мэдээлж, 21 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.7-д заасны дагуу байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 224 нь хугацаандаа, 2 нь хугацаа хоцроож мэдээлж, Сэлэнгэ баялаг ирээдүй, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг, Хүдэр тохижилт зэрэг 3 ОНӨААТҮГ нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.8-д заасны дагуу төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 890 удаагийн 2,569.3 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлэхээс 863 удаагийн 2,409.0 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлж, Мандал сумын 3-р сургууль нь 5 удаагийн 84.1 сая төгрөгийн, Шаамар сумын 1-р цэцэрлэг нь 5 удаагийн 13.9 сая төгрөгийн, Шаамар сумын ЕБС нь 4 удаагийн 10.9 сая төгрөгийн зэрэг нийт 27 удаагийн 160.3 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй байна.

## 1.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлсэн эсэх?

Аймгийн ЗДТГ, ИТХ нь төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбаргүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.” гэж хуульчилсан байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд орон нутгийн төсөвт 174, аймаг, сумдын ТЕЗ 18, ОНӨААТҮГ болон ОНӨҮГ 14 зэрэг нийт 206 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас түүвэрчилэн 17 сумын ЗДТГ, аймагт төвд байршилтай 12 орон нутгийн төсөвт байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбартай аудитын явцад танилцахад дараах байдалтай байна. Үүнд:

- Баруунбүрэн, Жавхлант, Ерөө, Хушаат, Цагааннуур, Шаамар, Түшиг зэрэг 7 сум нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг баримталж, тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-д заасан төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мөнгөн болон бусад гүйлгээний мэдээллийг бүрэн тусгаж, мэдээллээ тухай бүр шинэчлэн, иргэд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлсэн байна.

Ерөө сумын ЗДТГ



Шаамар сумын Дулаанхан тосгоны ЗАА



- Зарим төсөвт байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлын самбар нь цөөн төрлийн мэдээлэл байршихаар хийгдсэн байгаа нь төсөв, санхүүгийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх зарчмыг алдагдуулж, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог сулруулж байна. Тухайлбал:

“Сэлэнгийн долгио чуулга”



“Гэр бүл хүүхэд хөгжлийн газар”



Аймгийн ЗДТГ, ИТХ нь төсөв, санхүүгийн ил тод байдлын самбаргүй байгаа бөгөөд мэдээллээ аймгийн СТСХ-ийн мэдээллийн самбарт байршуулж байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой ач холбогдолтой байх, тогтсон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх гэсэн зарчмыг зөрчсөн байна.

Иймд тус хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах байгууллагууд нь мэдээллийн самбартаа 4 дүгээр зүйлд заагдсан зарчмыг баримталж, 3 дугаар зүйлийн 3.2-т заасан мэдээллүүдийг агуулсан, 7 дугаар зүйлд заасан эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан мэдээллийг байршуулж, иргэд, олон нийт мэдээлэлтэй нээлттэй, чөлөөтэй танилцах боломжоор хангах шаардлагатай байна.

## Бүлэг II

*Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх*

*Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллээ байршуулаагүй байна.*

**2.1. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх?**

*Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээлэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.*

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК -д хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1, 6.8.3-д заасан мэдээллүүд хамааралгүй бөгөөд 6.8.2-т заасан 3 төрлийн мэдээлэл, 6.10-д заасан мэдээллүүдийг бүрэн байршуулсан

боловч 6.8.2-т заасан мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, 6.10-д заасан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдэгдлүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Зураг 1

№	ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ												БУСАД				
		2018 1 сар	2018 2 сар	2018 3 сар	2018 1-р улирал	2018 4 сар	2018 5 сар	2018 6 сар	2018 Харас жил	2018 7 сар	2018 8 сар	2018 9 сар	2018 3-р улирал	2018 10 сар	2018 11 сар	2018 12 сар	2018 Бүтэн жил	
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
2	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	
3	Концессийн мэдээлэл (Тухай бүр)	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	
4	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 306.7 сая төгрөгийн шатахуун, 160.0 сая төгрөгийн автозамын битум худалдан авах нээлттэй тендерийг 2018 оны 4-р сард, 40.0 сая төгрөгийн өөрөө буулгагч автомашин 2 ш, 25.0 сая төгрөгийн үйлчилгээний автомашин, 48.0 сая төгрөгийн замын цагаан будаг худалдан авах тендерийг 1,4,6-р саруудад харьцуулалтын аргаар тус тус зохион байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав./

Тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэн “Шатахуун, шатах тослох материал худалдах, худалдан авах” гэрээг Ник ХХК-тай, “Автозамын битум худалдан авах” гэрээг Гийх зам ХХК-тай, “Өөрөө буулгагч автомашин худалдан авах” гэрээг Халиун ХХК, Таван үндэс ХХК-тай, “Үйлчилгээний автомашин худалдан авах” гэрээг иргэн П.Азжаргалтай, “Замын цагаан будаг худалдан авах” гэрээг Бүүвэй интернешнл ХХК-тай тус тус байгуулсан байна.

Шилэн дансны 4,6-р сарын мэдээнд нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан тендерийн ерөнхий мэдээллийг байршуулсан бөгөөд 5,8 дугаар сарын тендерийн ерөнхий мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

**2.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх?**

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллээ байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д заасны дагуу 10,0 сая төгрөөс дээш үнийн дүн бүхий улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 155 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч болох 128 аж ахуйн нэгжид /давхардсан тоогоор/ 13,178.0 сая

төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулж, 6,820.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 4-д харуулае/

Хүснэгт 6 /сая төгрөгөөр/

№	Хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо	ААН-ийн тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт өссөн дүнгээр	Санхүүжилтийн хувь
1	2017 оны ажил	7	5	620.9	620.9	100.0
2	Сумдын ХО	26	23	1,076.6	810.3	75.3
3	Сумдын ОНХС	25	23	1,422.3	973.5	68.4
4	Аймгийн ХО	40	29	3,642.8	1,533.8	42.1
5	Аймгийн ОНХС	22	21	1,575.5	959.3	60.9
6	Замын сангийн ХО	17	11	340.3	142.54	41.9
7	УТХО	12	10	4,018.8	1,298.9	32.3
8	Байгаль хамгаалах арга хэмжээ	6	6	480.8	480.8	100.0
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>155</b>	<b>128</b>	<b>13,178.0</b>	<b>6,820.04</b>	<b>51.8</b>

Дээрх 155 төсөл арга хэмжээг 97 ААН, байгууллага гүйцэтгэсэн бөгөөд эдгээр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг ЗГ-аас тогтоосон журмын дагуу улирал бүр мэдээллэх ёстойгоос нэг ч ААН, байгууллага мэдээлэл байршуулаагүй, 8 ААН, байгууллага цэс үүсгэсэн боловч мэдээлэл байршуулаагүй байна.

Цэс үүсгэсэн ААН, байгууллагыг дурдвал:

Аригшан ХХК, Өнөр зам ХХК, Тотал импекс ХХК, Хангай хятруун ХХК, Чаминхаус ХХК, Маргад монгол ХХК, Ноён тооромт ХХК, Татан оргил ХХК.

Сэлэнгэ аймагт улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 оны 10-р сараас 2018 оны 10-р сарын хооронд санхүүжигдан хэрэгжсэн 13,178.0 сая төгрөгийн 155 төсөл арга хэмжээнээс 88 ААН, байгууллага нь 1-2 төсөл арга хэмжээ, 9 ААН, байгууллага нь 3-аас дээш төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнийг тодруулбал:

Хүснэгт 7

№	Байгууллагын нэр	Төсөл арга хэмжээний тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт өссөн дүнгээр
1	Сүж ундарга ХХК	3	75	27.4
2	Сүлд ханба ХХК	3	195	46.4
3	Өнөр зам ХХК	3	80.4	64.1
4	Сайхан төгөл ХХК	4	111.2	92.5
5	СИОН ХХК	4	149.9	49.8
6	Сэлэнгэ таван хан ХХК	5	1330	109.2



7	Есөн хэлхээ ХХК	7	454	163.8
8	“Сэлэнгэ Есөн-Эрдэнэ” ХХК	8	884.8	251.5
9	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	12	2200.5	1072.9
	<b>Нийт дүн</b>	<b>49</b>	<b>5480.8</b>	<b>1877.6</b>

Хүснэгтээс харахад дээрх 9 ААН, байгууллага нь нийт санхүүжилтийн 41.6 хувь буюу 5,480.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аж ахуй нэгж байгууллагын цэс үүсгэх, мэдээлэл байршуулах үүргийг ажил үйлчилгээ гүйцэтгүүлж буй гэрээнд тусгаж, санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих харилцааг хууль болон холбогдох журамд нарийвчлан зохицуулаагүйтэй холбоотой байна.

Иймд ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээнд гүйцэтгэгчийн шилэн дансанд мэдээлэх үүрэг, хариуцлагын талаар тусгах, хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан болон хүлээлгэх хариуцлагыг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-д тодорхой тусгах шаардлагатай байна.

### **2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх?**

*Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 177 удаагийн мэдээллээс 27 удаагийн мэдээллийг хугацаанд нь, 38 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн буюу 36.7 хувийг мэдээлсэн байна.*

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д заасны дагуу төрийн чиг үүрэгт хамаарах 75 ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 55 хуулийн этгээдэд 3,679.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулж, 2,681.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 5-д харуулав/

*Хүснэгт 8 /сая төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	ТАХ-ний тоо	ААН-ийн тоо	Нийт санхүүжилт ийн хэмжээ	Олгосон санхүүжилт өссөн дүнгээр	Санхүүжилтийн хувь
1	Хувийн сургууль	3	2	298,5	260,1	87,1
2	Хувийн цэцэрлэг	7	4	471,5	418,8	88,8
3	Ахмадын хороо	2	1	63,4	55,4	87,4
4	Аймгийн албан журмын даатгуулагчдын холбоо	2	1	111,3	102	91,6
5	ӨЭМТ	14	7	1143	983,1	86,0

6	МЭҮН	18	11	225	206	91,6
7	Халамж	29	29	1366,3	655,9	48,0
	<b>Дүн</b>	<b>75</b>	<b>55</b>	<b>3679</b>	<b>2681,3</b>	<b>82,9</b>

2018 оны 3 дугаар улирлын байдлаар Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т хамаарах 55 хуулийн этгээд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 177 удаагийн мэдээллээс 27 удаагийн мэдээллийг хугацаанд нь, 38 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн буюу 36.7 хувийг мэдээлсэн байна.

Хүснэгт 9

Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Мэдээлбэл зохих	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорч мэдээлсэн	Нийт мэдээлсэн дүн	Мэдээлсэн хувь
Ерөнхий боловсролын сургууль	2	5	5	-	5	100.0%
Сургуулийн өмнөх боловсрол	4	14	0	10	10	71.4%
Ахмадын холбоо	1	4	0	4	4	100.0%
Албан журмын даатгагчдын холбоо	1	4	0	3	3	75.0%
Эрүүл мэндийн төв	7	28	19	9	28	100.0%
Мал эмнэлэгийн үйлчилгээний нэгж	11	35	3	12	15	42.9%
Халамжийн үйлчилгээ	29	87	0	-	-	0.0%
<b>Дүн</b>	<b>55</b>	<b>177</b>	<b>27</b>	<b>38</b>	<b>65</b>	<b>36.7%</b>

Дээрх 75 ажил үйлчилгээг 55 хуулийн этгээд гүйцэтгэсэн бөгөөд эдгээр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг ЗГ-аас тогтоосон журмын дагуу улирал бүр мэдээллэх ёстой.

Хуулийн 3.1.5-д хамаарах 55 хуулийн этгээдэд 2,681.3 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 39 хуулийн этгээдэд олгосон 831.5 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Үүнийг байгууллага тус бүрээр харуулбал:

## Хүснэгт 10

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Сумын нэр	Нийт төсөвт өртөг / сая.төг /	Санхүүжилт өссөн дүнгээр / сая.төг /	Шилэн дансанд байршуулаагүй мэдээлэл				
						Тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд гаргасан зардал өссөн дүнгээр / сая.төг /	4-р улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал
						тийм-1, үгүй-2				
1	Азтай цэцэг ХХК	СӨБ-ын үйлчилгээ	Сайхан	40.1	30.8	30.8			2	2
2	Албан журмын даатгагчдын холбоо	даатгалын үйлчилгээ	Сүхбаатар	54.3	45.0	45.0				2
3	Лхачинбу мал эмнэлэг	Мал эмнэлгийн үйлчилгээ	Ерөө	12.8	12.8	12.8	2	2	2	2
4	"Дэвжих дөл" ХХК	Мал эмнэлгийн үйлчилгээ	Цагааннуур	10.3	10.3	10.3	2	2		
5	Анар уул ББН	Мал эмнэлгийн үйлчилгээ	Орхонтуул	10.5	10.5	10.5	2	2		
6	Батцэнгүүн	Мал эмнэлгийн үйлчилгээ	Баруунбүрэн	17.6	17.6	17.6		2		
7	Бүрэнсүрэг	Мал эмнэлгийн үйлчилгээ	Баруунбүрэн	10.7	10.4	10.4			2	2
8	Тавансуварга	Мал эмнэлгийн үйлчилгээ	Мандал	13.4	13.4	13.4		2		
9	Цөм сүрэг ББН	Мал эмнэлгийн үйлчилгээ	Сайхан	13.9	13.9	13.9	2	2	2	2
10	ЭГДЭМ нөхөрлөл	Мал эмнэлгийн үйлчилгээ	Орхон	10.9	10.9	10.9			2	
11	Суманд цаасан хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх /29 ААН, байгууллага/	Халамжийн үйлчилгээ		1366.3	655.9	655.9		2	2	2
<b>Нийт дүн</b>				<b>1,560.8</b>	<b>831.5</b>	<b>831.5</b>	<b>4</b>	<b>7</b>	<b>6</b>	<b>6</b>

Дээрх хүснэгтийг тодруулж авч үзвэл:

- ХХҮГ-тай гэрээ байгуулан хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлж байгаа 29 хуулийн этгээд нь цэс үүсгээгүй, мэдээлэл байршуулаагүй
- Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа Лхачинбуу, Дэвжих дөл, Анар уул, Цөм сүрэг зэрэг 4 МЭҮН нь цэс үүсгэсэн боловч мэдээлэл байршуулаагүй,
- Батцэнгүүн, Бүрэн сүрэг, Таван суварга, Эгдэм зэрэг 4 МЭҮН нь 2018 оны 1, 2, 3-р улиралд мэдээллээ байршуулаагүй,
- СӨБ-ын үйлчилгээ үзүүлж байгаа Азтай цэцэг ХХК нь 2018 оны 2,3-р улиралд, Сэлэнгэ аймгийн Албан журмын даатгалын холбоо нь 2018 оны 3-р улиралд тус тус мэдээллээ байршуулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь тус тайлангийн 2.2-д дурдсан дүгнэлттэй ижил шалтгаантай бөгөөд цаашид ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээнд гүйцэтгэгчийн шилэн дансанд мэдээлэх үүрэг, хариуцлагын талаар тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан болон хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай байна.

**Бүлэг III**

*Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх?*

*Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулаагүй байгаа тул ТЕЗ-ийн зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.*

**3.1 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан байгууллага, албан тушаалтнууд холбогдох хяналтыг хэрэгжүүлсэн эсэх?**

*ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан боловч багийн иргэдийн Нийтийн Хурлын зүгээс хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.*

Шилэн дансны тухай хуулийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Аудитаар аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон багийн иргэдийн Нийтийн Хурлын зүгээс хяналт, шалгалт хийсэн эсэх талаар судалгааг нэгтгэн авч үзэхэд Аймгийн ИТХ болон Зүүнбүрэн сумын ИТХ-аас бусад 15 сумдын ИТХ-аас тус бүр нэг удаа хөндлөнгийн хяналтыг хийсэн байна.

Багийн иргэдийн Нийтийн Хурлын зүгээс хөндлөнгийн хяналт, шалгалтыг хийхээр хуульчлагдсан боловч Баруунбүрэн сумаас бусад нийт 16 сумдын багийн иргэдийн Нийтийн Хурлаас бусад нь хуулийг хэрэгжүүлж хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 247 дугаар албан бичгээр “аймаг, сумдын ИТХ болон багийн ИТХ-ын зүгээс хуулийн хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих талаар тодорхой журам, заавар чиглэл ирүүлээгүй тул 2019 онд Шилэн дансны тухай хуульд хөндлөнгийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар журам боловсруулан батлуулж, мөрдүүлэх арга хэмжээг авахаар төлөвлөж байна.” гэсэн тайлбарыг ирүүлсэн байна. Иймээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллагуудын чиг үүрэг, хэрэгжүүлэх арга зүйг тусгасан нэгдсэн журмыг боловсруулж, мөрдүүлэх нь зүйтэй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд бүх шатны ИТХ-ын 83.3 хувь нь хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлсэн бол багийн иргэдийн Нийтийн Хурлын зүгээс хуулинд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.2 дахь “Төрийн болон, орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэсэн заасан.

Дээрх чиг үүргийн дагуу аймгийн ТЭЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2018 оны 1, 2, 3 –р улиралд тус бүр 1, нийт 3 удаа орон нутгийн төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

2018 онд хэрэгжүүлсэн хяналтын шалгалтын дүн

Хүснэгт 11

Хуулийн этгээдийн төрөл	2017 оны I-IV улирал	2018 оны II улирал	2018 оны III улирал
Аймаг, сумдын ТЭЗ	18	18	18
ТЭЗ-ийн харьяаны орон нутгийн болон ТЗШ-ийн байгууллага	173	172	125
ОНӨААТҮГ	13	12	11
Төрийн нэрийн өмнөөс үйлчилгээ явуулдаг өрхийн ЭМТ, МЭҮН, хувийн сургууль, цэцэрлэг, ТББ	58	59	0
<b>Нийт хамрагдсан хуулийн этгээдийн тоо</b>	<b>262</b>	<b>261</b>	<b>154</b>
Цахим хуудсанд байршуулах мэдээллийн тоо	30399	7469	10636
Цахим хуудсан байршуулсан мэдээллийн тоо	28243	6668	9912
Цахим хуудсан байршуулсан мэдээлэл хувиар	93	89.3	93

2018 оны 1-р улиралд нийт 262 хуулийн этгээдүүдийн 2017 оны хуулийн хэрэгжилтийг хамруулан шалгаж, мэдээлэл байршуулалтыг 93 хувьтай гэж дүгнэж, Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг дутуу байршуулсан 39 төсвийн байгууллагын удирдлагад хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлж, төрийн чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлэгч 14 байгууллагын санхүүжилтийг түр хугацаагаар зогсоох хүсэлтийг аймгийн ЗДТГ-ын СТХС-ийн даргад тус тус хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

2018 оны 1-р улиралын хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар нийт 261 хуулийн этгээдийг хамруулан шалгаж, мэдээлэл байршуулалтыг 89.3 хувьтай, 2018 оны 1-2 –р улиралын хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтад 154 хуулийн этгээдийг хамруулан шалгаж, мэдээлэл байршуулалтыг 93 хувьтай гэж дүгнэсэн байна.

Тус албанаас Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг сайжруулах зорилгоор нэгдсэн байдлаар болон ажлын байрны сургалтуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

- Алтанбулаг, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Мандал сумын Түнхэл тосгон, Сант, Түшиг, Шаамар сумдын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийхдээ ажлын байранд нь болон нэгдсэн байдлаар сургалт зохион байгуулсан байна.
- Баруунбүрэн, Зүүнбүрэн, Сүхбаатар сумдын ИТХ-ын төлөөлөгчдөд шилэн дансны мэдээлэл байршуулалтад хяналт тавих талаар сургалт зохион

*байгуулж, гарын авлагаар хангасан байна. Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэстэй хамтран сумдын ЗДТГ-ын дарга нарт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулжээ.*

Аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт , аудитын албанаас Шилэн дансны тухай хуулинд заасан чиг үүргийг хэрэгжүүлж тайлант онд нийт 3 удаа хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн байна.

### **3.2 Хуулийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хяналтыг хэрэгжүүлсэн эсэх?**

*Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулаагүй байгаа тул ТЕЗ-ийн зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.*

Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д заасны дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага нь 10 сая төгрөгөөс дээш төгрөгийн үнийн дүнгээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн тухай бүр нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах үүрэгтэй.

Гэвч тайлант хугацаанд 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13,178.0 сая төгрөгийн 155 төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлэхээр давхардсан тоогоор 128 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, 6,820.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч дээрх аж ахуйн нэгжүүд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй бөгөөд 8 аж ахуйн нэгж байгууллага цэс үүсгэсэн байдалтай байна.

Иймээс хуулинд заасан шаардлагын дагуу аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллийг цахим, хуудас болон самбарт байршуулах ажилд санхүүжилт олгосон байгууллагын удирдлагууд болон ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны зүгээс хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2018 оны 1 дүгээр улиралд хийсэн хяналт шалгалтаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа хувийн сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, ахмадын холбоо, албан журмын даатгуулагчдын холбоо зэрэг нийт 58 хуулийн этгээдүүдийн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг шалгасан байна. Шалгалтын дүнг үндэслэн дээрх хуулийн этгээдүүд мэдээлбэл зохих мэдээллийн 73.7 хувийг мэдээлсэн гэсэн дүгнэлтийг өгсөн байна. Шалгалтаар 1 өрхийн ЭМТ, 1 хувийн цэцэрлэг, 1 хувийн сургууль, мал эмнэлгийн 9 нэгж, албан журмын даатгуулагчдын холбоо, аймгийн

ахмадын холбоо зэрэг нийт 14 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулаагүй байсан зөрчлийг арилгуулсан байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т хамаарах 55 хуулийн этгээд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих мэдээллийн 36.7 хувийг мэдээлсэн буюу хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь ХХҮГ-тай гэрээ байгуулан хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлж байгаа 29 хуулийн этгээд нь цэс үүсгээгүй, мэдээлэл байршуулаагүй, Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа 4 МЭҮН нь цэс үүсгэсэн боловч мэдээлэл байршуулаагүй байгаатай холбоотой байна. Иймд санхүүжилт олгож байгаа байгууллага болон Санхүүгийн хяналт аудитын албаны зүгээс дээрх аж ахуй нэгжүүдийн мэдээлэл байршуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох мэдээллийг бүрэн байршуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

### **3.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцаж, мэдээлэл нь ойлгомжтой, ач холбогдолтой байгаа эсэх?**

*Тухайн нэгж байгууллагын Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хандсан хэрэглэгчийн тоог хянах бололцоогүй, мөн иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан ач холбогдолтой мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд шуурхай өгч байгаа эсэхэд дүгнэлт өгөх бололцоогүй байна.*

Шилэн дансны нэгдсэн цахим сайтаас хэрэглэгчийн хандалтын тоон үзүүлэлтийн мэдээлэл авах боломжгүй байна.

Аудитын явцад Сүхбаатар, Сайхан, Мандал сумдын нийт 134 иргэнээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнгийн талаар санал, асуулга авсан бөгөөд үр дүнг нэгтгэн хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 12

№	Асуулт	Хариулт	Хувь	Тоо
			100%	134
1	Та төрийн байгууллагуудын төсөв, санхүүгийн талаар ямар мэдээлэл авахыг сонирхдог вэ?	Батлагдсан төсөв	35.8%	48
		Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт	38.8%	52
		Байгууллагын бүтэц орон тоонд гарсан өөрчлөлт	14.9%	20
		Бусад	10.5%	14
2	Та сонирхсон мэдээллээ хаанаас олж авч байна вэ?	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	56.0%	75
		Танилаасаа	11.9%	16
		Байгууллагын цахим хуудас	14.2%	19
		Байгууллагын шилэн дансны мэдээллийн самбар	6.7%	9

№	Асуулт	Хариулт	Хувь	Тоо	
			100%	134	
1	Та төрийн байгууллагуудын төсөв, санхүүгийн талаар ямар мэдээлэл авахыг сонирхдог вэ?	Батлагдсан төсөв	35.8	48	
		Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт	38.8	52	
		Байгууллагын бүтэц орон тоонд гарсан өөрчлөлт	14.9	20	
		Бусад	10.5	14	
2	Та сонирхсон мэдээллээ хаанаас олж авч байна вэ?	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	56	75	
		Танилаасаа	11.9	16	
		Байгууллагын цахим хуудас	14.2	19	
		Байгууллагын шилэн дансны мэдээллийн самбар	6.7	9	
		Шилэн дансны нэгдсэн цахим сан	1.5	2	
		Бусад	9.7	13	
3	Та сонирхсон мэдээллээ олж авч чаддаг уу?	Тийм	55.2	74	
		Үгүй	26.9	36	
		Мэдэхгүй	17.9	24	
4	Аймаг орон нутгийн төр, төсвийн байгууллагууд шилэн дансны мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлж байна гэж үзэж байна уу?	Тийм	45.5	61	
		Үгүй	27.6	37	
		Мэдэхгүй	26.9	36	

**Санал асуулга 1:** Та төрийн байгууллагуудын төсөв, санхүүгийн талаар ямар мэдээлэл авахыг сонирхдог вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан иргэдийн 35.8 хувь нь батлагдсан төсвийн, 38.8 хувь нь хөрөнгө оруулалт тендер худалдан авалтын, 14.9 хувь нь байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлтийн, 10.5 хувь бусад мэдээллийн талаар мэдээлэл авахыг сонирхдог гэсэн хариултыг өгсөн байна.

**Санал асуулга 2:** Та сонирхсон мэдээллээ хаанаас олж авч байна вэ? гэсэн асуултад хамрагдсан иргэдийн 56 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 11.9 хувь нь танилаасаа, 14.2 хувь нь байгууллагын цахим хуудаснаас, 6.7 хувь нь байгууллагын шилэн дансны мэдээллийн самбараас, 1.5 хувь нь шилэн дансны нэгдсэн цахим сангаас гэж хариулсан байна.



График 1



График 2




**Санал асуулга 3:** Та сонирхсон мэдээллээ олж авч чаддаг уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан иргэдийн 55.2 хувь нь сонирхсон мэдээллээ олж авч чаддаг бол, 26.9 хувь нь авч чаддаггүй, 17.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

**Санал асуулга 4:** Аймаг орон нутгийн төр, төсвийн байгууллагууд шилэн дансны мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлж байна гэж үзэж байна уу? гэсэн асуултад 45.5 хувь нь нээлттэй, ил тод мэдээлж байна, 27.6 хувь нь мэдээлж чадахгүй байна, 26.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

График 3



График 4



Судалгааны дүнг нэгтгэн авч үзвэл иргэдийн 75 хувь нь байгууллагын батлагдсан төсөв, хөрөнгө, оруулалт, тендер худалдан авалттай холбоотой мэдээллийг илүү сонирхдог, сонирхсон мэдээллээ 56 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр олж авдаг, хэрэгцээтэй мэдээллээ 55 хувь нь авч чадаж байна, 45.5 хувь нь шилэн дансны мэдээллийг ил тод нээлттэй мэдээлж байна гэж хариулсан байна. Гэвч санал асуулгад оролцсон иргэдийн 1.5 хувь нь “шаардлагатай мэдээллээ Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авч байгаа” гэж хариулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх гэсэн” үндсэн зорилт бүрэн хэрэгжихгүй байх эрсдлийг үүсгэхээр байна.

Иймээс Шилэн дансны нэгдсэн цахим сайт <http://www.shilendans.gov.mn> –д байршсан мэдээлэлтэй иргэд, олон нийт хэрхэн танилцах талаар сургалт суртчилгаа зохион байгуулж, мэдээллээр хангах ажлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс анхаарч ажиллах нь шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 9-р зүйлд заасан иргэний хяналтын талаар аудитад хамрагдсан байгууллагын удирдлага болон аймаг, сумдын ЗДТГ-ын өргөдөл гомдол хариуцсан ажилтнуудаас асуулга авахад иргэдээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой санал хүсэлт ирүүлээгүй байна.

### **3.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.**

*Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн бол зөвлөмжийн биелэлт 75 хувьтай байна.*

2017 оны 11-р сард хийж гүйцэтгэсэн аудитаар шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих мэдээллийг огт мэдээлээгүй “Сэлэнгэ үржлийн цөм сүрэг” ОНӨААТҮГ болон мэдээлбэл зохих мэдээллийн 50.0-52.9 хувийг байршуулаагүй Орхонтуул сумын 1, 2 сургуулийн холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Аудитаар албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны Б/48, Б/49, Б/50 дугаар захирамжаар Орхонтуул сумын 1, 2-р сургуулийн захиралуудад 2 сарын хугацаатай үндсэн цалинг 20 хувиар бууруулах, “Сэлэнгэ үржлийн цөм сүрэг” ОНӨААТҮГ-ын даргад 3 сарын хугацаатай үндсэн цалинг 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулж, албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2017 оны 3-р улиралд хийсэн аудитаар аймгийн Засаг даргад 2, сумдын ИТХ-ын дарга нарт 2, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт 2 нийт 6 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн 75 хувийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтэд товч байдлаар дүгнэж илэрхийлбэл:

*Хүснэгт 13*

д/д	Зөвлөмж өгөгдсөн албан тушаалтан	Зөвлөмжийн утга	Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байдал	Хэрэгжилтийн хувь
1	Аймгийн Засаг дарга Ш.Оргилд	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа хуулийн этгээдүүдийн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим санд бүрэн байршуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.	ТЕЗ-ийн зүгээс Санхүүгийн хяналт, дотоод алба болон аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналтын мэргэжилтэн, бүх сумдын санхүүгийн албаны дарга нарын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгуулан харьяа хуулийн этгээдүүдийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	100
2		Төрийн чиг үүрэгт хамаарах, ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэж буй аймгийн Ахмадын холбоо болон албан журмын даатгуулагчдын холбоо, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн мэдээллийг шилэн дансанд байршуулах.	Аймгийн ахмадын холбоо холбогдох мэдээллийг бүрэн мэдээлсэн, албан журмын даатгуулагчдийн холбоо 2018 оны 3 дугаар улиралын мэдээллийг дутуу мэдээлсэн. Тайлант хугацаанд нийт 18 МЭҮН 10.0 сая төгрөгөөс дээш санхүүжилтийг авсан ба үүнээс 4 МЭҮН цахим хуудсан мэдээллийг огт байршуулаагүй, 4 МЭҮН мэдээллийг дутуу мэдээлсэн бол 9 МЭҮН мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.	80
3	Сумдын ИТХ-ын дарга нарт	Багийн иргэдийн Нийтийн хурлын дарга нарын ажлыг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан эсэхийг гол үзүүлэлт болгож байх.	Багийн иргэдийн Нийтийн Хурлын зүгээс хуулинд заасан заасан чиг үүргийн дагуу хөндлөнгийн хяналт шалгалтыг хийгээгүй байна.	6
4		Шилэн дансны хуульд заасны дагуу хөндлөнгийн хяналт хийж, үнэлэлт, дүгнэлт өгч хэвших.	Аймаг, сумдын 18 ИТХ-ын 15 нь буюу 83.3 хувь нь хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн байна.	83
	Төрийн болон орон нутгийн	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлэх.	Өмнөх онд хийсэн аудитаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээлбэл зохих мэдээллийн 83 хувийг мэдээлсэн байсан	88

5	өмчит хуулийн этгээдийн		бол тайлант оны аудитаар нийт мэдээллийн 92.8 хувийг байршуулсан байна.	
6	дарга, захирал нарт:	2017 оны 3 дугаар улирлын байдлаарх дутуу мэдээлсэн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим санд 2017 оны 12-р сарын 20-ны өдрийн дотор нөхөн байршуулах.	Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу 2017 оны 3-р улиралын байдлаар дутуу оруулсан мэдээллийг нөхөж оруулсан байна.	90

## АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих **10,208.2 сая** төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ. Үүнд:

**1. 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн мэдээллийг байршуулаагүй нийт 1,651.3 сая төгрөгийн. Үүнд:**

- *ШШГЕГ-ын 433-р хаалттай хорих анги, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар, ИХШХЕГ-ын Хойд бүс дэх газар, Шаамар МСҮТ зэрэг 4 байгууллага 23 худалдан авалтын 597.2 сая төгрөгийн,*
- *Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 12 байгууллага 45 худалдан авалтын 821.7 сая төгрөгийн,*
- *Цант орхон ОНӨААТҮГ нь 7 удаагийн 232.4 сая төгрөгийн.*

**2. Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй 632.8 сая төгрөгийн. Үүнд:**

- *ШШГЕГ-ын 433-р хаалттай хорих анги, Шаамар сумын МСҮТ, Сайхан сум дахь сум дундын цагдаагийн тасаг зэрэг 3 байгууллага 8 удаагийн 165.7 сая төгрөгийн,*
- *Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 15 байгууллага 34 удаагийн 416,2 сая төгрөгийн,*
- *Цант орхон ОНӨААТҮГ нь 5 удаагийн 50.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээ.*

**3. 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлээгүй 112.2 сая төгрөгийн. Үүнд:**

- *ШШГЕГ-ын 433-р хаалттай хорих анги 9 удаагийн 70.8 сая төгрөгийн,*
- *Цант орхон ОНӨААТҮГ нь 1 удаагийн 41.4 сая төгрөгийн орлогын гүйлгээ.*

**4. Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаар мэдээлээгүй 160.3 сая төгрөгийн. Үүнд:**

- *Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 11 байгууллага 25 удаагийн 159.5 сая төгрөгийн,*
  - *Цант орхон, Туулийн хишиг ОНӨААТҮГ-ууд нь тус бүр 1 удаагийн 0.4 сая төгрөгийн шийдвэрийг.*
5. Сэлэнгэ аймагт төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэгч 39 байгууллага 831.5 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй,
  6. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 155 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч болох 97 аж ахуйн нэгж 6,820.1 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй,
  7. Тухайн жилийн төсвийг 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 2, орон нутгийн болон ТЗШ-ийн 9 байгууллага, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 20 хуулийн этгээд мэдээлээгүй,
  8. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 5, орон нутгийн болон ТЗШ-ийн 74 байгууллага, 6 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 85 хуулийн этгээд мэдээлээгүй,
  9. Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 1, орон нутгийн болон ТЗШ-ийн 29 байгууллага, 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 40 хуулийн этгээд мэдээлээгүй,
  10. 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 2, орон нутгийн болон ТЗШ-ийн 21 байгууллага, 5 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 27 хуулийн этгээд мэдээлээгүй,
  11. 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 1, орон нутгийн болон ТЗШ-ийн 15 байгууллага, 4 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 20 хуулийн этгээд мэдээлээгүй,
  12. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 3, орон нутгийн болон ТЗШ-ийн 41 байгууллага, 6 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 50 хуулийн этгээд мэдээлээгүй,
  13. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 6, орон нутгийн болон ТЗШ-ийн 50 байгууллага, 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 66 хуулийн этгээд мэдээлээгүй,
  14. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг улирал бүр мэдээлэхээс улсын төсвийн 1, орон нутгийн болон ТЗШ-ийн 12 байгууллага, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 16 хуулийн этгээд мэдээлээгүй,
  15. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг орон нутгийн болон ТЗШ-ийн 2 байгууллага, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 5 хуулийн этгээд мэдээлээгүй,
  16. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон

- өөрчлөлтийн талаарх мэдээллийг 2 орон нутгийн өмчит аж ахуйн мэдээлээгүй,
17. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг улсын төсвийн 1, орон нутгийн болон ТЗШ-ийн 16 байгууллага, 4 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 21 хуулийн этгээд мэдээлээгүй,
18. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж мэдээлээгүй зэрэг зөрчил илэрлээ.

### **АУДИТЫН ДҮГНЭЛТ**

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12091 удаагийн мэдээллээс 11260 удаагийн буюу 92.8 хувийг мэдээлсэн байна.
2. Аймгийн ЗДТГ, ИТХ нь төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбаргүй байна.
3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллээ байршуулаагүй байна.
5. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 177 удаагийн мэдээллээс 27 удаагийн мэдээллийг хугацаанд нь, 38 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн буюу 36.7 хувийг мэдээлсэн байна.
6. ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан боловч багийн иргэдийн Нийтийн Хурлын зүгээс хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.
7. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулаагүй байгаа тул ТЕЗ-ийн зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
8. Тухайн нэгж байгууллагын Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хандсан хэрэглэгчийн тоог хянах бололцоогүй, мөн иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан ач холбогдолтой мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд шуурхай өгч байгаа эсэхэд дүгнэлт өгөх бололцоогүй байна.
9. Өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн бол зөвлөмжийн биелэлт 75 хувьтай байна.

### **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

**Сумдын ИТХ-ын дарга нарт:**

- Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлын зүгээс харьяа хуулийн этгээдүүдийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байх талаар үүрэг, чиглэл өгч биелэлтэд хяналт тавьж ажиллах.

**Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаад:**

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллагатай байгуулах гэрээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд заасан мэдээллийг байршуулах үүргийг тусгаж, хэрэгжилтийг харгалзаж санхүүжилт олгож байх.

**Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Б.Дарихжавт:**

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны зорилго, холбогдох мэдээллийг цахим хуудаснаас хэрхэн авч ашиглах талаар иргэдэд сургалт, суртчилгаа зохион байгуулах.
- Аудитад хамрагдсан 97 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагатай хамтран ажиллаж, Шилэн дансны тухай хуулийн 6.9-д заасан мэдээллийн байршуулалтад хяналт тавих.
- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамрагдах Сэлэнгэ баялаг ирээдүй, Хүдэр тохижилт ОНӨААТҮГ-уудын цэсийг үүсгэж, Шилэн дансны тухай хуулинд заасан мэдээллийн байршуулалтад хяналт тавьж ажиллах.

**Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Л.Зоригтбаатарт:**

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан аж ахуй нэгж буюу хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд заасан мэдээллийг байршуулах үүргийг тусгаж, хэрэгжилтийг харгалзаж санхүүжилт олгож байх.

**Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт:**

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлэх.
- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан аж ахуй нэгж, байгууллагатай байгуулах гэрээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд заасан мэдээллийг байршуулах үүргийг тусгаж, хэрэгжилтийг харгалзаж санхүүжилт олгож байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

С.БАТ-ЭРДЭНЭ

З.ЗОЛБОО



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
АУДИТЫН АЛБА

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,

2018.11.28 № 165.  
танай 2018.11.28 -ны № 171 -г

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Ч.ЭНХТУЯА ТАНАА

Тайлангийн төсөлд тайлбар санал

хүргүүлэх тухай

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 10 дугаар сарыг дуусталх хугацааг хамруулан хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлийг хүлээн авч танилцлаа.

Тайлбар 1-ийг үзнэ үү

Тайланд дараах асуудлыг хянан үзэхийг санал болгож байна. Үүнд:

1. Нийцлийн аудитын тайлангийн төслийн 2 дугаар бүлгийн 2.3-д Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага нэгжид тус аймагт үйл ажиллагаа явуулж төсвөөс санхүүжилт авдаг 44 МЭҮН байдаг боловч 11 гэж бичсэнийг залруулах
2. Тус албанаас шилэн дансны мэдээлэл байршуулалтад байнга хяналт шалгалтад хамрагдсан 144 байгууллагад тусгайлсан аудит хийж дүнг танилцуулгад бичиж хүргүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авсан, Алтанбулаг, Шаамар, Түшиг, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Сант сум, Түнхэл тосгонд ажиллахдаа ажлын байранд нь болон нэгдсэн байдлаар сургалт зохион байгуулж дээрх хугацаанд 286 албан тушаалтныг хамруулсан. Зүүнбүрэн, Баруунбүрэн, Сүхбаатар сумын ИТХ-ын төлөөлөгчдөд шилэн дансанд мэдээлэл байршуулалтад хяналт тавих талаар сургалт зохион байгуулж, гарын авлага боловсруулсан өгсөн, Сүхбаатар сумын ИТХ-ын төлөөлөгчидтэй хамтран төсвийн байгууллагуудын шилэн дансанд мэдээлэл байршуулалтад аудит хийж зөвлөмж хүргүүлсэн, бүх сумдын Тамгын газрын дарга нарт аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулсан зэргийг оруулах.
3. Зөвлөмж хэсэгт аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга А.Эрдэнэгэрэлд "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулахдаа шилэн дансны цахим хуудсанд цэс үүсгэх тухай тусгаж, мөн 97 аж ахуйн нэгжтэйгээ холбоо барьж мэдээлэл нөхөн байршуулах ажлыг 2018 оны 12 дугаар сард багтаан шийдвэрлүүлэх гэж нэмэх
4. Дүгнэлт хэсэгт тус албанаас хийсэн ажлыг үнэлж дүгнэж бичих
5. Хавсралт хүснэгтүүдийг харах боломжгүй байгаа тул цахим хаягаар ирүүлэх.

Тайлбар 3-ыг үзнэ үү

Тайлбар 4-ыг үзнэ үү

Тайлбар 5-ыг үзнэ үү

ДАРГА



Б.ДАРИХЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТҮҮНД  
ӨГСӨН ТАЙЛБАР****Тайлбар 1:**

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэн төсвөөс санхүүжилт авдаг 44 МЭҮН байгаа боловч аудитад хамрагдсан тайлант хугацаанд 11 МЭҮН нь 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр үйлчилгээ үзүүлсэн байна. Иймд тайланд залруулга хийх шаардлагагүй болно.

**Тайлбар 2:**

Тус саналыг хүлээн авч Санхүүгийн хяналт, аудитын албаны зүгээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулсан сургалтын талаар тайлангийн 3.1-д нэмж өөрчлөлт оруулав.

**Тайлбар 3:**

Тус саналыг хүлээн авч аймгийн ЗДТГ-ын дарга, Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга нарт зөвлөмжийг хүргүүлэв.

**Тайлбар 4:**

Тайлангийн 3.1 дэх хэсэгт ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаны хэрэгжүүлсэн хяналтын талаар дүгнэлтийг тусгасан байсан тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

**Тайлбар 5:**

Тайлангийн хавсралт судалгааг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны [Sankhuu\\_audit\\_se@yahoo.com](mailto:Sankhuu_audit_se@yahoo.com) хаягаар хүргүүлсэн болно.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/188

Сүхбаатар

┌ АУДИТЫН ТАЙЛАН, ДҮНГ БАТЛАХ ТУХАЙ ┐

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.3, МУ-ын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралт, 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторт Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмжийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг УАГ-ын Нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, Засаг дарга Ш.Оргил, ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа, Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Б.Дарихжав, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Л.Зоригтбаатар, сумдын ИТХ-ын дарга болон Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад хүргүүлж, [www.audit.mn](http://www.audit.mn) цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Дарга, гэрүүлэх аудиторовн  
оны 11 сарын 30 өдрийн  
дугаар тушаалын хавсралт

/мян.төг/

д/д	Зөрчлийн утга	Зөвлөмж	Нийт зөрчил
1	5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн мэдээллийг байршуулаагүй	1,651.3	1,651.3
2	Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй	632.8	632.8
3	5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлээгүй	112.2	112.2
4	Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаар мэдээлээгүй	160.3	160.3
5	Сэлэнгэ аймагт төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэгч 39 байгууллага санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй	831.5	831.5
6	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 155 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч болох 97 аж ахуйн нэгж санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй	6,820.1	6,820.1
	<b>Нийт дүн</b>		<b>10,208.2</b>